

Нийгмийн ажил

ХУУЛЬ САХИУЛАХ БАЙГУУЛЛАГААС ХЭЛ, ЯРИАНЫ
БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭДЭД ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ
ҮЗҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ

ISSUES TO BE CONSIDERED BY LAW ENFORCEMENT
ORGANIZATIONS IN PROVIDING HELP AND SERVICES TO CITIZENS
WITH LANGUAGE AND SPEECH DISABILITIES



Н.Бадамцэцэг

*Дотоод хэргийн их сургуулийн
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албаны сургуулийн
магистрант, ахлах ахлагч*

Товч утга: Хууль зүй, Дотоод хэрэг, Онцгой байдлын боловсролын салбарыг түшиглэн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийг хууль, эрх зүйн мэдлэгтэй болгох, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцуулах зорилгоор өгүүллийг бичлээ.

Abstract: Based on the field of Law, Internal Affairs, and Emergency Education, the article was written in order to make citizens with hearing and speech disabilities aware of law and law, and actively participate in social relations.

Түлхүүр үгс: Хүний эрх, дохионы хэл, боловсролын байгууллага, төрийн байгууллагын үйлчилгээ, сонсголын бэрхшээлтэй хүн, хэл ярианы бэрхшээлтэй хүн, дохио зангаа.

Keywords: Human rights, sign language, educational institutions, services of public institutions, hearing-impaired people, speech-impaired people, gestures.

Монгол Улсын Үндсэн хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт Хүнийг үндэс, угсаа, ХЭЛ, арьсны өнгө, нас, хүйс нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна гэж зүйлчлэн заасан боловч хуулийн хэрэгжилт сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд тэр бүр үйлчлэхгүй байна.

Эх хэл гэдэг нь аливаа улс, үндэстний оршин тогтнох, үндэсний онцлогоо харуулах амин чухал ач холбогдолтой зүйл бөгөөд хувь хүн нийгэмд эзлэх байр

суурь, боловсрол эзэмших, өөрийн байр суурь, нийгмийн харилцаанд ороход чухал үүрэг гүйцэтгэдэг.

Шинжлэх ухаанд дохионы хэлийг Дактилология (dactylologie or fingerspelling) буюу хурууны үсэг, дохио зангаа (Signed language)-ны гэсэн 2 үндсэн хэсэгт хуваан, хараагаар хүлээн авах хэл (visual language)-ний томоохон салбарыг судалж иржээ.

Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй гэж Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12. 1 дэх хэсэгт заасан байдаг.

Монгол дохионы хэл нь баялаг олон жилийн түүхгүй дөчин жилийн гэртээгээс хөгжиж байгаа харьцангуй хөгжлийн түүх, судлагдсан байдал багатай салбар юм.

Хөгжлийн бэрхшээлтэй буюу сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэд өөрсдийн эх хэл болох дохионы хэлээр төрийн үйлчилгээг түргэн шуурхай авах боломж өнөөг хүртэл аль ч шатны байгууллагад хомс байна. (Монгол улсын хэмжээнд 20 гаран дохионы хэлний хэлмэрч байдаг)

Хууль, эрх зүйн туслалцаа шаардлагатай болох үед сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй шууд харьцах, анхан шатны тусламж, үйлчилгээг тухайн чиглэлээр үзүүлэх мэргэшсэн дохионы хэлний мэргэжилтэнгүй байгаа нь эдгээр иргэдэд орхигдсон, мартагдсан, гадуурхагдсан мэдрэмжийг төрүүлж, төрдөө, нийгэмдээ гомдсон гомдолтойгоор өнөөг хүрсэн.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуульд жилд 20-25 хүүхэд элсэн орж, 14-25 хүүхэд бүрэн дунд боловсрол эзэмшин төгсөж, та бидэнтэй хөл нийлүүлэн алхаж байна.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн Монгол дохионы хэлээр хоорондоо бүрэн ойлголцдог бөгөөд хэл бичгийн чадварыг энгийн сонсголтой иргэдтэй адилаар 12 жилийн хугацаанд эзэмшиж чаддаггүй, үйл үг холбох, утгыг дөхүүлэх төдий хэмжээнд эзэмшин төгсдөг нь жил бүр их дээд сургуульд элсэн суралцахаар Монгол хэл, бичгийн шалгалт өгч байгаа сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдийн ЭЛСЭЛТИЙН ЕРӨНХИЙ ШАЛГАЛТ-ын онооноос харж болох юм. /150-340/

Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ MNS 6752:2019 стандартын 6 дугаар хэсэг “Хүн төвтэй хандлагыг хөхиүлэн дэмжих зарчим”-ын дагуу Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүн бүр өөрсдийн эх хэл болох Монгол дохионы хэлээр хууль эрх, зүйн туслалцаа дэмжлэг авах эрхтэй гэж дурджээ.


Хэдийгээр сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүмүүс оюун ухаан, бие махбодын хувьд хэвийн, эрүүл боловч Монгол хэл бичгийн чадварыг бүрэн эзэмшээгүй, бичгийн хэлээр бусадтай бүрэн ойлголцох чадвар сул байдаг.

Энэ шалтгаанаас үүдэн хэл, яриа, сонсголын бэрхшээлтэй иргэд нийгмийн харилцаанд идэвхтэй оролцох, өөрсдийгөө бүрэн ойлгуулах, таниулах байдал нь хязгаарлагдмал, мөн дохионы хэлээр л зөвхөн ойлголцдог зэрэг нь эрүүл, сонсголтой бидний зүгээс эдгээр хүмүүст туслан, нийгмийн харилцаанд татан оролцуулах, хууль, эрх зүйн орчныг нь бүрдүүлэх, хүнлэг, энэрэнгүй нийгмийг бүтээх, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд тэдний эх хэл болох Монгол дохионы хэлээр эрх зүйн баримт бичгийг тайлбарлах, хууль хүчний байгууллагаас анхан шатны тусламж авах, тэднийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд хэрэгцээтэй дохионы хэлний мэдлэгийг эзэмших шаардлагыг үүсгэж байгаа бөгөөд Хууль зүй, Дотоод хэрэг, Онцгой байдлын салбарыг түшиглэн сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах зорилгоор энэхүү өгүүллийг бичлээб


Нэгдсэн Үндэсний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдөр баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-д Монгол Улс нэгдэн орж, Монгол Улсын Засгийн газар 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц”-ийг соёрхон баталсан байдаг.

Мөн Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн яамны дэргэдэх Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах орон тооны бус зөвлөлийн 01 дүгээр албан даалгаврын хэсэг бүрд “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих, орчныг бүрдүүлэх тухай нэг бүрчлэн заан тусгасан байдаг ч дорвитой ажил хийгддэггүй, Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдэг ойлголтыг тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэнээр төсөөлөн, тэдэнд зориулсан нийтийг хамарсан ажлыг тэргэнцэртэй иргэн явахад зориулсан налуу зам хийх ажлаар хязгаарлаж байгаа нь харамсалтай бөгөөд сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн орчны хүртээмж, эрх зүйн боловсрол олгож, тэдэнд туслахад чиглэгдэн судлагдсан бие даасан бүтээл хомс байна. *(Хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж бие махбод, оюун санаа, сэтгэл мэдрэл, мэдрэхүйн байнгын согог нь орчны бусад саадтай нийлсний улмаас бусдын адил нийгмийн амьдралд бүрэн дүүрэн, үр дүнтэй оролцох чадвар нь хязгаарлагдсан хүнийг хэлдэг бол: Сонсголын бэрхшээл гэж Сонсгол, хэл ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас хүний сонсох чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна; Ярианы бэрхшээл гэж Хэл, ярианы эрхтний гэмтэл, согог, өвчин эмгэгийн улмаас ярих хэвийн үйл ажиллагааны чадвар алдагдсан буюу хязгаарлагдсан хүнийг хамруулна;*

Манай улсын нийт хүн ам 2021 оны судалгаагаар 3049939 байсан бөгөөд мөн оны хөгжлийн бэрхшээлтэй нийт 106169 иргэдийн тоон судалгаатай харьцуулахад хөгжлийн бэрхшээлтэй иргэд хүн амын 3 хувийг эзэлж байна. (зураг 1) /нийт сонгогч, хэл ярианы бэрхшээлтэй 12504 иргэн/



Зураг 1



Зураг 2

Үндэсний статистикийн хорооны 2021 оны жилийн эцсийн байдлаар гаргасан судалгаагаар манай улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй нийт 106169 иргэн байна. (зураг 2) Тухайлбал:

- Хөдөлгөөний бэрхшээлтэй 21011;
- Сэтгэцийн бэрхшээлтэй 20414;
- Харааны бэрхшээлтэй 11695;
- Сонголын бэрхшээлтэй 8430;
- Ярианы бэрхшээлтэй 4074;
- Хавсарсан 7430;
- Бусад бэрхшээлтэй 33115 иргэн байна.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэн аливаа төрлийн гэмт хэргийн холбогдогч, хохирогч болсон тохиолдолд нэн түрүүнд хууль зүйн туслалцаа авахаар цагдаагийн байгууллагад хандаж, хохирсон, холбогдсон асуудлаа өргөдөл хэлбэрээр Цагдаагийн байгууллагад өгөхөд дохионы хэлний мэдлэггүйн улмаас өргөдлийг хүлээн авалгүй буцаах, заавал тухайн хэл ярианы бэрхшээлтэй хохирогч, холбогдогчийн асран хамгаалагчаар хэн нэгнийг байлцуулах шаардлага үүсгэдэг бөгөөд цаашлаад дохионы хэлний хэлмэрч, орчуулагчийг байлцуулах шаардлагатай байгаа талаар албан бичгийг Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургууль руу хүргүүлэх ажиллагаа зохион байгуулдаг ч сургуулиас хэлмэрч томилох боломжгүй, сонсголгүй иргэдийн холбоонд ханд гэснээр цаг хугацаа алдах, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн цагдаагийн байгууллагад итгэх итгэл, үнэмшил үгүй болдог.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж, хорих ял эдэлж байгаа харааны болон сонсголын бэрхшээлтэй нийт 43 хоригдол 14 хорих ангид ял эдэлж байгаагаас сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй 19, харааны бэрхшээлтэй 24 хоригдол байдаг тухай судалгааг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсээс гаргасан байдаг⁶³.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хоригдолтой харьцаж, нийгэмшүүлэх ажлыг хүртээмжтэй зохион байгуулах дохионы хэлний мэдлэгтэй, бэлтгэгдсэн мэргэжилтэн байдаггүй, тэдэнд хэрхэн нийгэмшүүлэх үйл ажиллагааг зохион байгуулдаг нь тодорхой бус үлдэж, зөвхөн тоон судалгаагаар хязгаарлагдаж өнөөг хүрсэн.

Магадгүй эдгээр иргэд өөрсдийн бэрхшээлээс шалтгаалан бүрэн дүүрэн өөрийгөө илэрхийлж гэм буруугүй, мөн тодорхой үнэн зөв мэдээллийг хүргэж, ойлгуулж чадаагүй, шууд харьцаж байгаа болон шүүн таслах ажиллагаанд оролцож буй албан тушаалтнууд дохионы хэлний мэдлэггүйгээс гаднаас хэлмэрч авах, авсан хэлмэрчид нь сонсголгүй иргэдийн эрх зүйн байдлыг нь дээрдүүлэх бус эсрэгээрээ байгааг үгүйсгэхгүй.

Энэ төрлийн бэрхшээлтэй иргэд өөрсдийн байр суурь, дуу хоолойгоо тэр бүр бүрэн илэрхийлэх, өөрт шаардлагатай мэдээллийг авах нөхцөл, боломж, сурч боловсрох орчны хүртээмж хязгаарлагдмал байдлаас болж мэдээ, мэдээллээс хочорч, хязгаарлагдмал, нуугдмал байдалтай байдаг.

Төрийн болон төрийн бус байгууллагад хэл яриа, сонсголын бэрхшээлтэй иргэд шаардлагатай мэдээллийг хүртээмжтэй байлгах, тайлбарлах мэргэшсэн хөтөч, бэлтгэгдсэн дохионы хэлний орчуулагч, боловсролын байгууллагад дохионы хэлний бэлтгэгдсэн чадварлаг багш, мэргэжилтэн тэр бүр байдаггүйгээс тэд төрийн байгууллагаар үйлчлүүлэхдээ ойлголцохгүй гэх шалтгаанаар өөрт хамаарал бүхий мэдээллийг лавлахаас зайлсхийж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрхээ бүрэн эдэлж чаддаггүйг харуулж байна.

Магадгүй дээр дурдагдсан шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болж хорих ял эдэлж буй хөгжлийн бэрхшээлтэй хоригдлуудад хууль тайлбарлах, гэмт хэргээс

⁶³ Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн 2021 оны жилийн эцсийн тайлан, судалгаа

урьдчилан сэргийлэх чиглэлээр эх хэлээр нь тайлбарлаж ойлгуулсан бол...гэх харамсал төрж байгааг нуухгүй.

Сонсголгүй хүн орчны хүртээмж хязгаарлагдмал, бусадтай өөрийн төрлөх хэл болох Монгол дохионы хэлээр ярилцах боломж хомс гэх шалтгаанаар сэтгэл гутралд амархан өртдөг бөгөөд үүнийг дагаад өөрийн амь, биедээ эрсдэл учруулах магадлал тун өндөр болдог.

Судлаач би дохионы хэлний дунд шатны мэдлэгтэй бөгөөд ажил, мэргэжлийн хувиар сонсголгүй иргэд, хоригдогсодтой ярилцахад дараах хүндрэлтэй асуудлууд тэдэнд тулгарсан байдаг. Жишээлбэл:

- ... дугаар ангид цагдан хоригдож байсан иргэн Э 32 настай, сонсголгүй, ЭХТА-ийн 17.1.2 дахь зүйлээр шалгагдаж байхдаа мөрдөгчтэй хийсэн байцаалтад хэлмэрчилсэн хэлмэрч дохионы хэлээр бус дохионы үсгээр яриад байсан ойлголцоогүй, ойлгомжгүй байсан, миний дохионы хэлээр ярьж байгаа зүйлийг хэлмэрч ойлгохгүй байсан гэх;

- ... дугаар ангид цагдан хоригдож байсан иргэн М 42 настай, сонсголгүй, ЭХТА-ийн 10.1.1 шалгагдаж байхдаа Өмгөөлөгчтэй хийсэн уулзалтын дараа асар их сэтгэлээр унасан, сэтгэл санаа тогтворгүй байсан бөгөөд өмгөөлөгчтэйгөө огт ойлголцоогүй, яриа нь ойлгомжгүй байсан, цаасан дээр бичилцэж, үсгээр ярилцсан, дохионы хэлээр яриагүй гэх;

- аймаг дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын шийдвэр гүйцэтгэгч хүүхдийн тэтгэлэг авдаг сонсголгүй иргэнтэй харилцах чадвар байхгүйн улмаас тухайн сонсголгүй ээж хүүхдийн тэтгэлэг авч чадалгүй хохирч үлдэж байлаа гэх;

- ... дугаар ангид хоригдож буй хоригдогч М-ийн эцэг, эх хэл яриа, сонсголын бэрхшээлтэй, бичиг үсгийн чадвар муугаас шалтгаалан эргэлт, уулзалтаар ирэхдээ ямар зүйл шаардлагатайг мэдээгүй гэх шалтгаантай, уулзалтын үеэр эргэлтээр авчирсан хүнсний бүтээгдэхүүнийг буцааж байсан гэх;

- Насанд хүрээгүй сонсголгүй, Н 2021 оны 10 дугаар сард Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газрын ... дугаар хэлтсийн хариуцан ажилладаг хэсэгт гар утсаа хулгайд алдсан, алдсан даруйдаа харьяалах Цагдаагийн байгууллагад хандсан боловч ойлголцохгүй гэх шалтгаанаар өнөөг хүртэл шийдэгдээгүй гэх мэт алба хаагчдын зүгээс энгийн иргэдэд хялбархан тайлбарлан ойлгуулдаг харилцааг сонсголгүй иргэдтэй харилцах дохионы хэлний мэдлэггүйн улмаас ойлголцож чадалгүй чирэгдэл үүсэх асуудлууд тулгардаг байна.

Өөрийн дохионы хэлний мэдлэгийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сум дахь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх хэлтэс, Цагдан хорих 461 дүгээр хаалттай анги, Дотоод хэргийн их сургуулийн музей, Сонгинохайрхан дүүрэг дэх Цагдаагийн газрын Замын Цагдаагийн хэлтэс зэрэг байгууллагад үйл ажиллагаа, өдөр тутамд мөрдөгддөг эрх зүйн баримт бичгийг дохионы хэлэнд хөрвүүлж, видео бэлтгэж иргэдэд үйлчлэх хэсэгт байршуулахад сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдээс талархал ирж байсан нь энэ төрлийн мэдээ, мэдээлэл хомс байдаг төдийгүй нэн шаардлагатайг харуулж байна.

Мөн Фэйсбүүк орчинд 1400 гишүүнтэй Сонсголын бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн бүлэг, 277 гишүүнтэй Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхийн холбооны нэгдсэн бүлэгт 7 хоногийн хугацаатай “Төрийн болон төрийн бус

байгууллагаас шаардлагатай мэдээ, мэдээллийг авч чаддаг уу?” гэх судалгааг авахад судалгаанд нийт 52 иргэн оролцож дараах байдлаар:

- Дохионы хэлтэй төрийн албан хаагч байдаггүй, ойлголцдоггүй, ихэвчлэн ар гэрээсээ хэн нэгнийг өөрийнхөө өмнөөс явуулдаг;

- Сонсголгүй иргэдэд зориулсан мэдээ, мэдээлэл хомс байдаг;

- Мэдээлэл авч чаддаггүй, шаардлагатай мэдээллээ сонсголгүй иргэдээсээ сургаар олж авдаг;

- Хууль, эрх зүйн талаарх мэдээ, мэдээлэл, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа бидэнд хүртээмжтэй байдаггүй;

- Ямар нэгэн байдлаар буюу хулгайд эд зүйлээ алдах, бусдад дээрэлхүүлэх тохиолдолд тэр бүр хуулийн байгууллагад хандаж чаддаггүй учир нь цагдаагийн байгууллагад гомдлоо гаргаад очиход заавал хэн нэгэн дагаж явах шаардлага үүсдэг тиймээс чирэгдэл болголгүй орхидог гэх хариултыг өгсөн.

Дээрх судалгаа, ажлын үр дүнг харахад сонсголгүй хүнд энгийн бидний өдөр тутамдаа ашигладаг эрх зүйн баримт бичгийг зайлшгүй дохиогоор хүртээмжтэйгээр хүргэх хэрэгцээ, шаардлага үүсэж байгааг харуулж байгаагаас гадна Монгол дохионы хэлний мэдлэгийг системтэйгээр сургалтын хуваарьт оруулах нь нэн түрүүнд шийдвэрлэх тулгамдаж буй асуудал болоод байна. *(Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7 дахь Төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд нь хөгжлийн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн оролцохыг баталгаажуулах зорилгоор тэднийг тохирох хэрэглэгдэхүүнээр хангах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлнэ...)*

Дүгнэлт, санал

Дотоод хэргийн их сургууль нь Цагдаа, Хилийн цэрэг, Дотоодын цэрэг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх, Шүүхийн шинжилгээ, Онцгой байдлын байгууллагад ур чадвартай, өндөр ёс зүй, өргөн мэдлэгтэй алба хаагчдыг бэлтгэн шууд ажлын байран дээр гаргадаг Монгол Улсын боловсролын салбарт тэргүүлэгч сургууль билээ. Энэ ч утгаараа хүний эрхийг эн тэргүүнд тавьж, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдтэй төвөггүйгээр харьцах чадварлаг мэргэжилтнийг бэлтгэн гаргах зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүсэж байгааг дээрх тоон судалгаа болон сонсголгүй иргэдээс авсан судалгаа, өнөөгийн байдал илтгэн харуулж байна.

Дотоод хэргийн их сургуулийн сургалтын хөтөлбөрт “Дохионы хэлний мэдлэг олгох” хичээл оруулж, сонсогч, суралцагч, оюутнуудад хөгжлийн бэрхшээлтэй хүн гэж хэнийг хэлэх, тэдэнтэй хэрхэн харьцах талаар ерөнхий ойлголтыг өгөөд орхих бус нарийвчлан судлуулж, цаашид суралцаж төгсөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэдтэй харилцааны түвшинд шууд төвөггүй ойлголцож, хууль, эрх зүйн туслалцаа, холбогдогч, хохирогч нарт цаг алдалгүй үзүүлэх ач холбогдолтой юм.

Сонсогч, суралцагч, оюутнууд дохионы хэлний мэдлэгтэй болсноор сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүний эрх бэлтгэгдэн гарсан алба хаагчдын мэдлэгт тулгуурлан аль ч шатанд хөндөгдөхгүй байх бүрэн боломжтой болно.

Хүний эрхийн мэдрэмжтэй байх ёстой мэргэжлийг эзэмшүүлж, хууль зүй, дотоод хэргийн салбарт чанартай боловсон хүчин бэлтгэн гаргаж буй Дотоод хэргийн их сургуулиас эхэлж өөрчлөлтийг бий болгон Монгол дохионы хэлний

мэдлэгийг сонсогч, суралцагсдадаа эзэмшүүлснээр сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдэд цаг алдахгүй хууль зүйн туслалцаа хүргэдэг нийгмийг бий болгоно.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн бага ангид элсэн орж байгаа хүүхдүүд 1.5 жилд цагаан толгойн 35 үсэг, мөн дохионы хэлийг дунд шатанд сурч, харилцааны хэмжээнд эзэмшдэг бөгөөд сонсголттой, төлөвшсөн том хүн 56 цаг буюу 1 семестрийн турш сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэнтэй харилцааны түвшинд анхан шатны мэдлэгийг авч чаддаг бол дунд түвшний дохионы хэлний мэдлэгийг 2 семестр судлах хугацаанд олж авах боломжтой, мөн практик хослуулсан тохиолдолд сургалтын үр дүнд ахиц гарах тухай Сонсголгүй боловсрол ТББ-аас судалж, хичээлийн хөтөлбөр болгон гаргасан байдаг.

Дотоод хэргийн их сургуулиас сургалтын хөтөлбөртөө Монгол дохионы хэлний цагийг бий болгон суралцагчдад дохионы хэлний мэдлэгийг дунд шатанд эзэмшүүлснээр сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй иргэдийн эрх аль ч шатанд хөндөгдөхгүйгээс гадна хүний эрхийг хангаж, боловсролын салбарт шат ахисан томоохон үйл явдал болох юм.

Эх сурвалжийн жагсаалт

1. Үндсэн хууль төрийн мэдээлэл эмхтгэл. 1992 он. №01
2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. төрийн мэдээлэл эмхтгэл 2016 он, №16
3. Монгол Улсын Их Хурлын 2017 оны 06 дугаар сарын 09 өдрийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 46 дугаар тогтоол
4. Стандартчилал, Хэмжил Зүйн Үндэсний зөвлөлийн 51 дүгээр тогтоол. 2009 он.
5. Монгол Улсын Засгийн газрын “хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай” 116 дугаар тогтоол 2017 он.
6. НҮБ “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенци” 2006 оны 12 дугаар сарын 13-ны өдөр;
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг хамт олонд түшиглэн хамруулан хөгжүүлэх үйлчилгээ MNS 6752:2019;
8. Үндэсний Статистикийн хорооны “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн судалгаа” 2021 он;
9. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн Хөгжлийн бэрхшээлтэй хоригдлын нэгдсэн судалгаа 2021 он;
10. Сонсголгүйн боловсрол ТББ-ын судалгаа 2022 он;
11. Монгол Улсын Засгийн газар “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенц” 2008 оны 12 дугаар сарын 19-ний өдөр;
12. Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын яам “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хууль, эрх зүйн орчин, стандартын хэрэгжилтийн өнөөгийн байдал” 2019 он
13. Legaldata.mn;
14. Сонсголын бэрхшээлтэй иргэдийн нэгдсэн групп;
15. Сонсголын бэрхшээлтэй хүүхэдтэй эцэг эхчүүдийн нэгдсэн групп;